

“Эрдэнэт суврага” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлан

Манай хувьцаат компани нь 2024-2025 онд Дорнод аймаг, Баян-Уул сумаас Цагаан давааны өвөр хүртэл 24км хатуу хучилттай авто замын Бага Үйлсийн гол 10,64 у/м гүүр, Үйлсийн голын 20,84 у/м төмөрбетон гүүрийн барилгын ажлыг хийн гүйцэтгэж байна.





2024-2025 онд Сэлэнгэ аймаг, Ерөө сумын төвөөс Бугант тосгон чиглэлийн 10,94 у/м хатуу хучилттай авто зам барилгын ажлыг хийн гүйцэтгэж байна.





Ерөө, Ерөө
Монгол Улс
Ерөө сум -Бугант чиглэлийн 27.8км
"Захиалагч ЗТЯ"
"Зөвлөх Хязгааргүй хөдөлгөөн"ХХК
"Гүйцэтгэгч : Эрдэнэт Суврага ХК"
пк4+820-пк 4+980далангийн өргөсөлт 2



Ерөө
Монгол Улс
Ерөө сум -Бугант чиглэлийн 27.8км
"Захиалагч ЗТЯ"
"Зөвлөх Хязгааргүй хөдөлгөөн"ХХК
"Гүйцэтгэгч : Эрдэнэт Суврага ХК"
пк3+500-пк4+020 далангийн өргөсөлт 1

Тус онд нийт 16 ажилтан албан хаагчтайгаар ажилсан бөгөөд, 218,040,000 төгрөгийн цалин хөдөлмөрийн хөлсийн ажилчдад цаг тухайд нь олгож, цалин хөдөлмөрийн хөлс болон Нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөргүй ажиллаж байна.

Компани татвараа үнэн зөв тодорхойлж, тайлагнах үүргээ нэр төртэй биелүүлж, нийгмийн хариуцлагаа ухамсарлаж 2024 оны 12 сарын байдлаар НДШимтгэлд 51,601,900 төгрөг, нийт татвард 34,567,524 төгрөгийг төлжээ.

Манай компани 2025 онд нийслэл болон орон нутгийн авто зам, гүүрийн ажлын тендерт оролцон борлуулалтын орлогоо тогтвортой өсөн нэмэгдүүлж, хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг олгох, өглөг авлагын хэмжээг бууруулах, техник тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөж байна.